



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Азжая
Утас: 99125777
Цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуун тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл



ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
У.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.25 № 02/118
танай _____-ны № _____-т

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбүрэн сумын татварын орлогын гүйцэтгэл 398.0 сая төгрөгөөр бүрдэж 5.4 сая төгрөгөөр тасарч биелсэн байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 30.5 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 4.2 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 4.2 сая төгрөгөөр тус тус орлого давж, ан амьтан нөөц ашигласны төлбөр 8.9 сая төгрөг сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 14.8 сая, хувь хүний орлогын албан татвар 30.5 сая, үйл ажиллагааны орлого 2.8 сая, ус рашаан ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,232.7 сая төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цалин хөлс нэмэгдэл урамшил 34.4 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 0.6 сая, сум хөгжүүлэх санд 20.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 32.1 сая төгрөг орж, хоршоо хөгжүүлэх сангаас 1 аж ахуй нэгжид 40.0 сая төгрөгийн зээл олгосон, ОНХС-гийн хөрөнгө оруулалтын 7.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээж аваагүй зэрэгтэй холбоотойгоор нийт 36.8 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн

дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 8/05 тогтоолоор Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 92.0 буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	599,662.20	323,757.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	190,244.30	73,457.90
33	АВЛАГА	221,764.20	187,708.30
34	УРЬДЧИЛГАА	8,500.00	3,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	179,153.70	59,091.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,252,541.60	2,257,014.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,252,541.60	2,257,014.60
39200	Биет хөрөнгө	4,129,953.80	2,232,039.70
39300	Биет бус хөрөнгө	122,587.80	24,975.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,852,203.90	2,580,772.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,330.30	18,532.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,330.30	18,532.30
41300	Өглөг	28,330.30	18,532.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,823,873.60	2,562,240.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,823,873.60	2,562,240.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,961,661.70	609,081.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,961,661.70	609,081.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,150,581.10	1,724,077.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,711,630.70	229,081.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,852,203.90	2,580,772.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,312,886.10	1,866,771.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	245,482.40	397,970.60
110	Орлогын албан татвар	41,811.70	155,848.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,811.70	155,848.70
113	Хөрөнгийн албан татвар	48,393.40	50,099.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	155,277.30	192,023.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	217,116.70	507,609.70
120	Нийтлэг татварын бус орлого	217,116.70	507,609.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,850,287.00	961,191.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,245,238.70	1,616,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,245,238.70	1,616,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,413,276.50	1,600,943.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,383,754.80	354,327.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,074.90	43,858.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,523.70	409,582.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,738.80	329,317.10
2105	Нормативт зардал	104,960.70	375
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,442.80	3,018.70
2107	Томилолт, зочны зардал	5,732.50	2,691.70

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,990.20	11,202.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	364,058.20	446,569.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	831,962.20	15,356.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	67,647.40	250,471.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	362	2,495,275.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	67,285.40	-2,244,803.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,121,415.30	1,395,305.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	245,482.40	397,970.60
110	Орлогын албан татвар	41,811.70	155,848.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,811.70	155,848.70
113	Хөрөнгийн албан татвар	48,393.40	50,099.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	155,277.30	192,023.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,475.50	8,697.60
1181	Газрын төлбөр	99.3	3,079.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	122,702.50	180,246.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,787.40	37,143.20
120	Нийтлэг татварын бус орлого	51,787.40	37,143.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,824,145.50	960,191.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,863,224.40	1,181,380.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,863,224.40	1,181,380.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,025,861.30	1,159,314.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,372,865.40	350,350.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,749.60	46,227.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,545.80	409,961.80
2104	Хангамж, бараа материалын зардал	56,818.00	15,219.70
2105	Нормативт зардал	79,251.50	318.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,923.90	3,533.90
2107	Томилолт, зочны зардал	6,485.20	2,691.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,736.20	19,876.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,485.70	311,134.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	837,363.20	22,066.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	258,190.80	213,924.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	91,514.30	290,711.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	91,514.30	290,711.30
2200	Дотоод эх үүсвэрээр	91,514.30	290,711.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-91,514.30	-290,711.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-12,700.00	-40,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	12,700.00	40,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	153,976.60	-116,786.40

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,267.80	190,244.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	190,244.30	73,457.90

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,756,872.1	4,756,872.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-283.9	-283.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,756,588.2	4,756,588.2
9	Тайлант үеийн үр дүн	67,285.4	67,285.4
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,823,873.6	4,823,873.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,823,873.6	4,823,873.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-16,830.1	-16,830.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,807,043.4	4,807,043.4
19	Тайлант үеийн үр дүн	-2,244,803.4	-2,244,803.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,562,240.0	2,562,240.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,269,498,100.0	1,232,689,797.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,786,800.0	901,978,497.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,515,500.0	881,707,197.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,733,900.0	350,350,307.9
210101	Үндсэн цалин	227,163,800.0	223,418,011.0
210102	Нэмэгдэл	57,932,200.0	57,918,796.9
210104	Урамшуулал	51,228,800.0	20,604,400.0
210105	Гэрээт ажлын хөлс	48,409,100.0	48,409,100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,086,100.0	46,227,800.0
210201	Тэтгэврийн даатгал	32,702,300.0	31,438,400.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,589,000.0	3,484,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,330,600.0	3,168,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	769,700.0	740,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,694,500.0	7,396,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	410,527,700.0	409,961,790.0
210301	Гэрэл, цахилгаан	15,149,000.0	15,149,000.0
210302	Түлш, халаалт	392,359,400.0	392,359,400.0
210303	Цэвэр, бохир ус	3,019,300.0	2,453,390.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,219,700.0	15,219,700.0
210401	Бичиг хэрэг	1,740,200.0	1,740,200.0
210402	Тээвэр, шатахуун	10,274,200.0	10,274,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,300.0	3,205,300.0
2105	Нормативт зардал	318,300.0	318,300.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	318,300.0	318,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,533,900.0	3,533,900.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	157,000.0	157,000.0

210604	Урсгал засвар	3,376,900.0	3,376,900.0
2107	Томилолт, зочны зардал	2,691,700.0	2,691,700.0
210702	Дотоод албан томилолт	2,691,700.0	2,691,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,606,500.0	8,606,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,496,000.0	7,496,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330,000.0	330,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	145,000.0	145,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.0	130,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.0	30,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,500.0	352,500.0
210807	Газрын төлбөр	123,000.0	123,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,797,700.0	44,797,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,447,700.0	44,447,200.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.0	350,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,271,300.0	20,271,300.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,914,700.0	4,914,700.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,914,700.0	4,914,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,356,600.0	15,356,600.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,549,600.0	13,549,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,807,000.0	1,807,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,711,300.0	290,711,300.0
220001	Барилга байгууламж	88,085,300.0	88,085,300.0
221001	Их засвар	83,963,800.0	83,963,800.0
222001	Тоног төхөөрөмж	59,270,800.0	59,270,800.0
223001	Бусад хөрөнгө	59,391,400.0	59,391,400.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000,000.0	40,000,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	40,000,000.0	40,000,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,269,498,100.0	1,224,816,166.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,228,893,100.0	1,192,084,797.9
320001	Орон нутгийн төсвөөс	998,929,300.0	962,120,997.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	229,963,800.0	229,963,800.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	40,605,000.0	32,731,369.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.0	605,000.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.0	32,126,369.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,000,000.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	49,220,667.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	39,552,124.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	98.0	98.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.0	6.0
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.0	46.0
620001	Удирдах ажилтан	9.0	9.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.0	11.0
620003	Үйлчлэх ажилтан	18.0	18.0
620004	Гэрээт ажилтан	8.0	8.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	46.0	46.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	10.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	24.0	24.0
650010	Гэрээт ажилтан	4.0	4.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.0	8.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	276,763,298.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,763,298.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	276,763,298.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,426,100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,426,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,337,198.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	266,337,198.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	276,763,298.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	276,763,298.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	269,666,498.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,096,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэбүрэн сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022

онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

Сумын Засаг даргын 2022 оны 07 сарын 30-ны өдрийн А/63 тоот "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн гүйцэтгэлд хяналт тавих захирамж, 2022 оны 05 сарын 13-ны өдрийн "Сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх" захирамжийг тус тус үндэслэн төсөвт байгууллагуудын болон орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийжээ. Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг 2022 онд шинэчлэн баталсан. Төсөв байгууллагуудын хөрөнгийн тооллогыг хагас жилээр хийж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн актлах хөрөнгийн жагсаалтыг сумын Иргэдийн төлөөлөгчид болон, аймгийн Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсэн байна.

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2771.4 сая төгрөгөөр буюу 46.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	190.2	73.5	-116.7
Авлага	221.7	187.7	-34.0
Урьдчилгаа	8.5	3.5	-5.0
Бараа материал	179.1	59.1	-120.0
Үндсэн хөрөнгө	4252.5	2257.0	-1995.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4852.2	2580.8	-2271.4
Богино хугацаат ер төлбөр	28.3	18.5	-9.8
Цэвэр хөрөнгө, өмч	4823.9	2562.2	-2261.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4852.2	2580.8	-2271.4

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн дансууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 190.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 73.5 сая төгрөг болж 116.7 сая төгрөгөөр буюу 61.4 хувиар буурсан байна. Ерөнхий орлого дансанд татварын болон татварын орлого буурсантай холбоотой байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 187.7 сая төгрөг болж, өмнөх оноос 34.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	54.9	13.9	(-41.1)
Хувь хүмүүсээс авах авлага	164.5	173.8	(9.3)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.4	0.1	(-13)
Дүн	221.7	187.7	(34.0)

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 34.0 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас 40.0 сая төгрөгийн зээл олгосон ба 30.3 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулсан, Улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой 28.1 сая төгрөгийн авлага буурсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн балансад бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн авлага, татаас санхүүжилтийн авлага 1.0 сая төгрөгийн авлага, Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй татаас санхүүжилтийн авлага мөн байгууллагаас авах авлага 14.1 сая төгрөгийн авлага, шилжиж барагдуулсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 3.5 сая төгрөг болж, өмнөх оноос 5.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	8.5	3.5	-5.0
Тусгай зориулалтын сан			-
Дүн	8.5	3.5	-5.0

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрдэнэбүрэн сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны эхний үлдэгдэл 8.5 сая төгрөгөөс тайлант онд 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж 3.5 сая төгрөгийн бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 59.1 сая төгрөг болж 120.0 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	10.0	0	0	0.0
Тусгай зориулалттай материал	0	0.00	0.0	0.0
Эм боох материал	10.0	0.00	10.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0.00	0.0	0.0
Хангамжийн материал	169.2	59.1	-110.1	0.0
Бичиг хэргийн материал	7.8	6.7	-1.1	0.1
Аж ахуйн материал	96.5	28.5	-68.0	0.3
сэлбэг хэрэгсэл	0	0.00	0.0	0.0
Түлш шатах тослох материал	0.0	0.00	0.0	0.0
Барилгын засварын материал	0.0	0.00	3.8	0.0
Хүнсний материал	9.5	0.0	-9.5	0.0
Бусад хангамжийн материал	42.5	12.3	-32.2	0.3
Мал амьтад	12.9	11.6	-1.3	1.0
Нөөцийн бараа	0	0.00	0.0	1.0
Нийт бараа материал	179.1	59.1	120.0	0.6

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 51.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 41.2 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.0 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад 130.2 сая төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5604.4 сая төгрөг байсан бол оны эцэст 2984.1 сая төгрөг болж 2620.3 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн байгууллагын 3127.0 сая төгрөгийг балансаас балансад шилжүүлж авч, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 15 ажлын өртөг 466.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 4 багийн засаг дарга нарт өөрийн болон засгийн хөрөнгийн оролцоотой 4 ширхэг 5.0 сая төгрөгийн мотоцикл гэх мэт хөрөнгүүдийг орлогод авч, 137.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28.3 сая, эцсийн үлдэгдэл 18.5 сая төгрөг болж 9.8 сая төгрөгөөр буурсан байна. Балансаас балансад 9.8 сая төгрөгийн өглөг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 4823.8 сая төгрөг байснаас оны эцэст 2562.2 сая төгрөг болж 2261.6 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,269.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,269.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1,269.5 сая төгрөгөөр анх баталж ирснийг сум ИТХ-ын 2021 оны 12 сарын 09-ны 4/05 тогтоолоор 1,269.5 сая төгрөгөөр баталсан. Өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор аймаг 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны 6/5 тоот тогтоолоор нийт 1,269.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 6/05 тоот тогтоолоор 1,269.5 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,269.5 сая төгрөгийн төсөв баталснаас 962.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 401.4 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 229.9 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 32.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 15.2 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлжээ.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын болон татварын бус орлого	405.0	402.0
Татварын орлого	403.4	398
Татварын бус орлого	1.6	4.0

Орон нутгийн төсвөөс санхүүжих	684.3	684.3
Орон нутгийн төсвөөс	454.4	454.4
Орон нутгийн хөгжлийн сан	229.9	229.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	55.2	47.2
Туслах үйл ажиллагааны орлогоос	40.0	32.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	65.6	65.6
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	1210.1	1133.5

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 454.4, орон нутгийн татварын болон татварын бус орлого 402.0, ОНХС-ийн санхүүжилт 229.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0, туслах үйл ажиллагааны орлого 32.1 буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хамтын гэрээний орлогоос, урьд оны үлдэгдлээс 65.6 сая төгрөгийг тус тус зарцуулах эрх нээлгэж нийт 1181.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1232.6 сая төгрөгийг зарцуулж 73.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйг 73.5 сая төгрөг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1232.7 сая төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 350.4 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 311.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 19.9 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 410.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 1 иргэнд 40.0 сая төгрөгийн зээл олгосон, нийт 36.8 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6сая туслах үйл ажиллагааны орлого 20.0 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 32.1 сая, хамтын гэрээний өөрийн орлого 0.6 сая нийт 32.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 12.1 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтийн орлого биелсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	403.4	351.7	-51.7
Нийт орлого ба тусламжийн дүн	1269.5	1232.7	36.8
Татварын орлого	403.4	398	5.4
Орлогын албан татвар	186.3	155.8	30.5
Хувь хүний орлогын албан татвар	186.3	155.8	30.5
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	129.5	124.1	(5.4)
Үйл ажиллагааны орлого	17.0	14.1	2.8
Шууд бус орлого	21.9	3.8	18.1
Хөрсөнгийн албан татвар	3,4	50,1	34.2
Үл хөдлөх эд хөрсөнгийн албан татвар	1.2	1,5	0,3
Бууны албан татвар	2,2	2,3	0,1
Малын тоо толгойн албан татвар	0.0	46.3	46.3
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	18.0	13.8	-4.2
Бусад татвар, төлбөр, хураамж	213.6	192.0	21.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	21.6	36.1	14.5
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	2.9	0.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	18.7	3.9	14.8

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.8	1.9	0.1
Газрын төлбөр	1.4	3.1	1.7
Газрын төлбөр	1.4	3.1	1.7
Дуудлага худалдаа	-	00	0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	189.3	180.2	9.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	186.8	177.9	8.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.00	0.9	0.1
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.5	1.5	0
Татварын бус орлого	706	720.6	
Нийтлэг татварын бус орлого	21.6	36.1	14.5)
Хувьцааны ногдол ашиг	-		-
Торгуулийн орлого	1.0	3.4	(2.4/
Төсөвт байгууллагын өөрийн орлого	20.6	32.7	12.1

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 401.4 сая төгрөг орж 3.1 сая төгрөгөөр тасарч биелсэн байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 30.5 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 4.2 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 4.2 сая төгрөгөөр тус тус орлого давж, ан амьтан нөөц ашигласны төлбөр 8.9 сая төгрөг сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 14.8 сая, хувь хүний орлогын албан тавар 30.5 сая, үйл ажиллагааны орлого 2.8 сая, ус рашаан ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЗДТГ-ын нэмэлт дансаар аймгийн Засаг даргын А/407 захирамжаар 2021 оны төсөвт байгууллагуудын халаалтын өр шүүхийн шийдвэрээр 230.3 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, ОНХС-ийн 2021, 2022 оны барьцаа хөрөнгө 14.0 сая, ИТХ-аас хүүхэд хамгааллын багт 0.3 сая, төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 1/40 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,531.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 50.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 40.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-нь байгууллагын төсвөөс хандив тусламж шагнал олгосон зөрчил илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 104.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 170.1 сая төгрөгийн 8 зөвлөмж өгөгдсөнийг Эрдэнэбүрэн сумын Соёлын төвд өгсөн 1.3 сая төгрөгийн зөвлөмж, 3.2 сая төгрөгийн албан шаардлагын биелэлт хангагдаагүй, СХС-д өгсөн 87.7 сая төгрөгийн албан шаардлагын биелэлт 50 хувь, бусад байгууллагад өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/сая төгрөгөөр/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Акт	-	-	-	-	-	-
Албан шаардлага	3	104.9	2	57.6	1	47.3	67.0
Зөвлөмж	8	170.1	6	103.9	2	3.2	98.0
Нийт дүн	11	275.0	8	161.5	3	50.5	82.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд гарч байгаа алдаа зөрчлийг асуудлын бүртгэлээр ТТЗ-д хүргүүлсэн ба орон нутгийн зүгээс дотоод хяналт тавьж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17.7 сая төгрөгийн алдаа¹ илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Аймгийн Засаг даргын А/693 захирамжаар Сумын тэжээлийн нөөцийн бэлтгэл эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг 10.0 сая төгрөг авч Аваргын ач ХХК-наас 473 уут хивэг тэжээл худалдан авсан боловч бараа материалд бүртгэж тайлагнаагүй.
- ОНХС-гийн хөрөнгөөр мал угаалгын ванн бариулж хүлээн авсан боловч үлдэгдэл 7.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, өглөгөөр бүртгэж тайлагнаагүй.

Аудитаар нийт 33.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.3 сая төгрөгийн албан шаардлага өгч, 33.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

- ✓ Бараа материал дансанд бүртгэлтэй байсан 43 тооны 0.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий мал амьтдыг акталж зарцуулсан данс бүртгэлээс хассан анхан шатны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримт байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 "үр ашигтай байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Малын нас дэвшлийн тооцоо бодож зах зээлийн ханшаар үнэлээгүй зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

5.2 Зөвлөмж

5.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв төлөвлөгөөнд батлагдаагүй хашааны нөхөн төлбөр 1.0, худгийн хаалга солиход 1.0, гүүр засварын ажил 15.0, нийт 17.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6. "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Иргэдийн саналаар эрэмбэлэгдэж батлагдсан төсөл арга хэмжээнээс бусад арга хэмжээг уг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх.*

5.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил, малын хөлийн татвараас орсон орлогоос хийгдсэн ажлуудад гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд алданги тооцох заалт оруулаагүйгээс гүйцэтгэсэн ажлын 90 хувь нь хугацаа хоцроож хүлээлгэн өгсөн, малын хөлийн татварын орлогоос гүйцэтгэсэн ажлуудыг хүлээж авах комиссын акт үйлдэж хүлээлгэн өгөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", гэснээс гадна гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа мөрдөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулснаар хөрөнгө оруулалтын үр өгөөж сайжирна, алданги тооцооноор танай суманд санхүүгийн үр өгөөж бий болох юм.

Өгсөн зөвлөмж: *Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд алданги тооцох заалт оруулж, төсөл арга хэмжээг хугацаандаа хүлээн авах, захиалагчийн хяналтыг сайжруулах.*

5.2.3 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ нь тушаалаар болон аж ахуй материал авахад зарцуулсан мөн баяр наадмын зардалд зарцуулсан мөнгөний анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 "үр ашигтай байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно".

Өгсөн зөвлөмж: *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, зардлыг санхүүжүүлэхгүй байх.*

5.2.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: ЗДТГ-ын засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3.3, ИТХ-ын бараа үйлчилгээний бусад зардлаас 3.5 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-ийг зөрчин хандив тусламж дэмжлэгт олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай

хуулийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглох заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах, Төсвөөс хандив тусламж олгохыг таслан зогсоох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг ЗДТГ дутуу бүртгэсэн	1	10.0	1	10.0			1	10.0	-	-
ОНХС өглөгт тусгаж тайлагнаагүй	1	7.7	1	7.7			1	7.7		
Дүн	2	17.7	2	17.7	-	-	2	17.7	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-гаас төсөв төлөвлөгөөнд батлагдаагүй арга хэмжээ санхүүжүүлсэн	1	17.0			1	17.0
ОНХС-гийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа мөрдөлт, алдангийн асуудал	1				1	
ЗДТГ-ын анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал	1	9.2			1	9.2

ЗДТГ-ын мал акталж зарцуулсан асуудал	1	0.3	1	0.3		
Дүн	4	26.5	1	0.3	3	26.2

Санхүүгийн тайлангийн аудитын илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл
/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин хандив тусламж олгосон /ЗДТГ, ИТХ/	2	6.8	-	-	-	-	2	6.8
Дүн	2	6.8	-	-	-	-	2	6.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИНСЭН:

ПХА007/066454

АУДИТОР:

Ц.АЗЗАЯА